

**“ЦАГ УУРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН”-ГИЙН  
ВЕБ СУУРЬТАЙ ПРОГРАМ ХАНГАМЖ**

---

**ГАРЫН АВЛАГА**

---


2023 он

## Оршил

Энэхүү платформыг Цаг уур, орчны шинжилгээний газрын архив мэдээллийн сангийн цаг уурын синоптик ажиглалтын мэдээллийг цахим хуудсаар дамжуулан хурдан шуурхай, хялбар байдлаар авах, төлбөр тооцоог интернэт сүлжээг ашиглан төлөх зэрэг үйлчилгээг үзүүлэх зорилготой хөгжүүлэв.

## Вебд хэрхэн бүртгүүлэх вэ?

Хэрэглэгч бүртгэх хэсэг дараах байдлаар харагдана (Зураг 1). Хэрэглэгчийн майл, өөрийн нэр, овог нэр, утас, нууц үг зэрэг мэдээллийг ашиглан бүртгүүлж, мэдээллийн санд нэвтэрнэ.



**E** Archive Meteorology

Email

Овог нэр

Өөрийн нэр

Утасны дугаар

Нууц үг

Нууц үг давтах

Бид хэрэглэгчийн хувийн мэдээллийг зөвхөн энэ хуудасны үйл ажиллагааг сайжруулах, аюулгүй, найдвартай ажиллагааг дэмжих зорилгоор ашиглана.

Зураг 1. Хэрэглэгч бүртгүүлэх

Бүртгүүлэх холбоос: <http://119.40.97.106/register>

## Вебд хэрхэн нэвтрэх вэ?

Хэрэглэгчийн нэвтрэх хэсэг дараах байдалтай харагдах бөгөөд утасны дугаар эсвэл мэйл хаягийн аль нэгийн ашиглан, нууц үгээ оруулж нэвтрэх боломжтой юм (Зураг 2).

Нэвтрэх холбоос: <http://119.40.97.106/login>

Зураг 2. Нэвтрэх цэс

## Хэрхэн нууц үг сэргээх вэ?


Хэрвээ та нууц үгийг мартсан бол нууц үг марсан холбоосыг ашиглан нууц үгээ өөрийн бүртгүүлсэн майл хаягаар дамжуулан сэргээх боломжтой (Зураг 3).

Нууц үг сэргээх холбоос: <http://119.40.97.106/reset-password>

Зураг 3. Нууц үг сэргээх.

## Хэрхэн хувийн мэдээллээ засах вэ?

Хэрэглэгч нь нэвтэрсний дараа мэдээлэл засах боломжтой бөгөөд баруун дээд буланд байгаа хэрэглэгчийн нэр дээр дарж “Мэдээлэл засах” хэсгийг сонгон өөрийн мэдээллээ засах боломжтой. Тухайн хэрэглэгч нь хуучин нууц үгээ заавал зөв оруулах ёстой. Хэрвээ буруу оруулсан тохиолдолд мэдээлэл шинэчлэх боломжгүй юм (Зураг 4).



akhmyetali02@gmail.com

Khamshybai

Akhmyetali

99859501

Хуучин нууц үг

Нууц үг

Нууц үг давтах

Засах

Зураг 4. Мэдээлэл засах хэсэг

## Хэрхэн мэдээ авах вэ?

Хэрэглэгч нь нэвтэрсний дараа дараах цонх харагдана (Зураг 5). Та дараах 2 цэсний хүрээнд ашиглах боломжтой.

“Шинээр мэдээ авах” хэсэг нь хэрэглэгч өөрийн хүссэн ажиглалтын мэдээ авахад шаардлагатай мэдээллүүдийг бөглөн “үргэлжлүүлэх” товчийг дарна. Хэрвээ мэдээлэл нь бүрэн биш бол үргэлжлүүлэх боломжгүй болно.


Зураг 5. Мэдээ авах.

## Хэрхэн төлбөр төлөх вэ?

Үргэлжлүүлэх товчийг дарснаар төлбөр төлөх суваг гэсэн хэсэг рүү шилжинэ. Үүнд “Qraу-ээр төлөх” гэсэн товчийг дарж QR код үүсгэнэ (Зураг 6).

Зураг 6. Төлбөр төлөх суваг

QR код нь дараах байдалтай харагдана (Зураг 7). Энэхүү QR кодыг уншуулан төлбөр тооцоогоо хийх боломжтой юм. Төлбөр төлсний дараа “Төлбөр баталгаажуулах” товчийг дарж төлбөр төлөгдсөнийг баталгаажуулна.



Зураг 7. QR код.

Төлбөр баталгаажуулсны дараа ажиглалтын мэдээг татаж авах болон майл хаяг руу илгээх гэсэн 2 сонголттой бөгөөд хүссэн сувгаар авах боломжтой (Зураг 8). Харин “Миний авсан мэдээ” хэсгийг ашиглан тухайн хэрэглэгч өөрийн авсан нийт үйлчилгээнүүдээ харах боломжтой.

Элемент	Хугацааны төрөл	Индекс	Төлбөрийн хэмжээ	Эхлэх хугацаа	Дууссан хугацаа	Үүсгэсэн хугацаа	Үйлдэл
tt_ave_tt_max_tt_min_wind_ave_wind_max_soil_tmax_rr_sum	year	43201000.47802000	<a href="#">Хүлээгдэж байна</a>	2009	2029	2023-07-21T11:29:00.000Z	<a href="#">↓</a> <a href="#">▶</a>
tt_ave_tt_max_tt_min_wind_ave_wind_max_soil_tmin_soil_tave	year	47812100.48610500.49011600	<a href="#">Хүлээгдэж байна</a>	2020	2027	2023-07-21T13:27:00.000Z	<a href="#">↓</a> <a href="#">▶</a>
tt_ave	year	48299900.44103600	<a href="#">Хүлээгдэж байна</a>	2020	2024	2023-07-21T16:43:00.000Z	<a href="#">↓</a> <a href="#">▶</a>

Зураг 8. Татаж авах хэсэг.